

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал 8	
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11. Шилэн дансны мэдээлэл	9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/336
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрүүл мэндийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн яамны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2019\0225SAG113.Docx

071007

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Эрүүл мэндийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 28-наас 2019 оны 02 дугаар сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Долгоржав, Д.Болор-Эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн яам 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 4-1/302 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрүүл мэндийн яамны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрүүл мэндийн яам нь *"Шударга өрсөлдөөн, сонголтод суурилсан, аюулгүй, чанартай эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг иргэн бүрд олгох олон улсын стандартад нийцсэн нөхцөлийг бүрдүүлэх явдал мөн"* гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Энэхүү зорилгын хүрээнд:

- эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичгийг боловсруулж эрүүл мэндтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;
- эрүүл мэндийн байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийг дэмжих, гадаад хамтын ажиллагааг эрүүл мэндийн салбарын бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хөгжүүлэх;
- нийгмийн эрүүл мэндийн бодлогыг зохион байгуулах, зохицуулах, олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- хүн амд хүртээмжтэй, чанартай, аюулгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээг дээшлүүлэх;
- эм, үйлдвэрлэл, эрүүл мэндийн технологийн бодлогыг зохицуулах, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлж, чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж ирсэн байна.

Эрүүл мэндийн яамны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааг төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Эрүүл мэндийн яамны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох

бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Донорын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамтай холбоотойгоор Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай, Донорын тухай хуулиуд батлагдан хэрэгжиж эхэлсэн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Эрүүл мэндийн яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрүүл мэндийн яам нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Axplorer 3.52” програм хангамж ашигладаг байна.

Эрүүл мэндийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөгүй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрүүл мэндийн яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсвийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн төсвийн зарцуулалтын мөнгөн урсгалд хяналт тавих үүднээс зардлын дансыг сонгов.

Эрүүл мэндийн яамны 2018 оны нийт зардал 19,894,497.4 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 198,945.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа,
зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	/мянган төгрөгөөр/	
			Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	31,527.5	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	5,665.8	
3	Албан шаардлага өгсөн	3	146,144.5	
	Дүн	6	183,337.8	

2.5. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

2018 оны 12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийг 5,665.8 мянган төгрөгөөр илүү төлж төсвийн хэмнэлтийн мөнгийг зарцуулсан, авлага үүсгэсэн.

Энэ нь “Хэмжилт”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 7 дугаар зүйлийн 7.3, 7.7 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлээгүйд Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1 дахь заалтуудыг үндэслэн төлбөрийн акт тогтоох.

2. Балансын данстай холбоотой асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 229 дүгээр “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” тогтоолоор “Монгол Солонгосын дорно дахины анагаах ухааны төв”-ийн эзэмшиж байгаа 105,613.4 мянган төгрөгийн өртөгтэй эмнэлгийн барилгыг данс бүртгэлд тусгасан боловч хөрөнгийн дахин үнэлгээг хийлгээгүй байна.

Энэ нь “Эрх ба үүрэг”, “Оршин байх” батламж мэдэгдлүүдтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын 2.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээнд хамрагдаагүй барилгыг дахин үнэлэх асуудлыг шийдвэрлүүлэх, бүртгэлд тусган ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх.

3. Балансын данстай холбоотой асуудал

Эрүүл мэндийн яамны 31 албан хаагчдад ээлжийн амралтын олговрыг бодож олгохдоо өмнөх оны амралтын мөнгийг дундаж цалинд оруулан тооцож нийт 6,855.4 мянган төгрөг, мөн амралтын дундаж цалинд унаа, хоолны хөнгөлөлтийг оруулан 50 албан хаагчид нийт 4,580.5 мянган төгрөг нийт 11,435.4 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь “Үнэн зөв байдал”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2000 оны 166 тоот тушаалын 2 дугаар хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Цалин болон амралтын олговрыг зөв тооцон олгож байх албан шаардлага хүргүүлэх.

4. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

"Мөнхийн тун" ХХК-д вакцин бараа нийлүүлэх 3 гэрээг 3,126,697.9 мянган төгрөгөөр байгуулсан боловч 4,074.8 мянган төгрөгийг илүү олгосон, гэрээний үүргийн биелэлтийн 5 хувь буюу 25,020.9 мянган төгрөгийг дутуу байршуулсан. Мөн "Мөнхийн тун" ХХК "Галзуугийн эсрэг вакцин" нийлүүлэх тендер шалгаруулалтаар "Хамгийн сайн" үнэлэгдэж, 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 2/57 дугаар албан бичгээр гэрээ байгуулах эрхийг хүргүүлж, 5 хоногийн дараа байгуулах атал бараа ажил үйлчилгээ нийлүүлэх гэрээг 01 дүгээр сарын 06-ны өдрөөр 01 дүгээр гэрээ байгуулж холбогдох хуулийн заалтыг зөрчсөн байна.

Энэ нь "Эрх ба үүрэг" "Оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангаагүй Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Холбогдох хуулийн заалтуудыг баримталж ажиллах, цаашид алдааг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний болон бусад зардлаар гаргасан ажил гүйлгээ, худалдан авах ажиллагааны хууль, журмын хэрэгжилт, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж буйг сайтар нягтлан үзэх нь зүйтэй байна.

Төвийн төлөвлөгөөг зөв оновчтой боловсруулж батлуулах шаардлагатай байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрүүл мэндийн яам чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 3 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 16,049,096.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 15,964,571.9 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна.

Тус яам үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 622,784.3 мянган төгрөг буюу 17.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг аудитын явцад дахин нягталж үзэхэд 87 хувьтай байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн яамны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрүүл мэндийн яам нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Багаж хэрэгслийн зардлаас 8,411.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 8,894.5 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 6,380.3 мянга, бусад зардлаас 1,460.0 мянга, нэмэлт санхүүжилтийн данснаас 7,757.6 мянган төгрөг нийт 22,027.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй, мөн зориулалтын бус зардлаас хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам”-ын 1.2 дахь заалт тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолыг ажилдаа хэрэгжүүлж, цаашид алдаа зөрчлийг давтахгүй ажиллах талаар зөвлөмж өгөх

2. Зардлын данстай холбоотой асуудал

"Эрүүл мэндийн салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах" 2018 оны 02 дугаартай 9,500.0 мянган төгрөгийн үнэтэй гэрээг “Мишээл-Од аудит” ХХК-тай байгуулсан бөгөөд анхан шатны баримтын бүрдэлгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь “Эрх ба үүрэг”, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв хөтөлж ажиллах талаар зөвлөмж өгөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	138,207,200.12	222,353,891.31
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,365,294.66	18,920,801.07
311	Кассад байгаа бэлэн мөнгө	20,801.07	20,801.07
31110	Төгрөг	20,801.07	20,801.07
312	Банканд байгаа бэлэн мөнгө	1,344,493.59	18,900,000.00
3121	Төгрөг	1,344,493.59	18,900,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	1,344,493.59	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	18,900,000.00
33	АВЛАГА	95,748,662.66	182,064,847.44
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	5,665,855.43
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	176,338,992.01
335	Бусад авлага	95,748,662.66	60,000.00
3351	Байгууллагаас авах авлага	95,748,662.66	60,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,093,242.80	21,368,242.80
354	Хангамжийн материал	41,093,242.80	21,368,242.80
35410	Бичиг хэргийн материал	-	831,000.00
35420	Аж ахуйн материал	10,133,919.00	12,775,919.00
35440	Түлш, шатах тослох материал	10,583,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	20,376,323.80	7,761,323.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,060,327,840.75	2,961,969,837.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,060,327,840.75	2,961,969,837.58
392	Биет хөрөнгө	4,039,418,476.13	2,851,685,922.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,278,178,470.99	1,377,218,119.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,747,690,759.10	-22,002,828.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	273,016,610.20	273,016,610.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	-164,783,932.19	-206,539,393.77
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,909,762,219.32	2,375,060,757.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-734,978,933.96	-1,126,633,215.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	413,190,510.71	422,593,692.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-259,114,097.30	-242,549,812.78
39209	Зам, гүүрний байгууламж	93,877,260.00	00.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-42,266,260.16	00.00
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	52,950,556.71	00.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-34,539,437.84	00.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,542,750.00	3,542,750.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,726,481.25	-2,020,756.29
393	Биет бус хөрөнгө	20,909,364.62	110,283,915.26
39301	Програм хангамж	41,629,990.00	38,317,990.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-20,720,625.38	-24,623,614.74
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	96,589,540.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,198,535,040.87	3,184,323,728.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	176,338,992.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	176,338,992.01
413	Өглөг	00.00	176,338,992.01
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	176,338,992.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,198,535,040.87	3,007,984,736.88
51	Засгийн газрын хувь оролцоо	4,198,535,040.87	3,007,984,736.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,646,011,001.40	2,742,600,541.40
51101	Өмч: - төрийн	2,646,011,001.40	2,742,600,541.40
512	Хуримтлагдсан үр дүн	1,148,185,969.09	-1,012,912,842.94
51210	Өмнөх үеийн үр дүн	1,148,185,969.09	1,148,185,969.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-2,161,098,812.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	404,338,070.38	1,278,297,038.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,198,535,040.87	3,184,323,728.89

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,491,108,887.27	19,878,858,323.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	975,273,043.39	763,668,983.97
120	Нийтлэг татварын бус орлого	638,181,513.39	627,886,334.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	638,181,513.39	627,886,334.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	638,181,513.39	622,784,334.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	5,102,000.00
122	Тусламжийн орлого	337,091,530.00	135,782,649.97
122001	Хандив тусламж /дотоод/	337,091,530.00	135,782,649.97
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,515,835,843.88	19,115,189,339.60
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	12,555,182,700.00	15,452,574,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,555,182,700.00	15,452,574,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,960,653,143.88	3,662,615,339.60
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,507,065,234.60
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	1,480,392,821.44	00.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	458,857,000.00	2,126,215,281.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,382,500.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,020,822.44	29,334,824.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	15,661,180,221.54	19,894,497,378.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,661,180,221.54	19,894,497,378.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,541,344,194.79	18,995,763,898.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,460,641,987.53	1,570,282,925.91
210101	Үндсэн цалин	1,087,846,543.92	1,173,509,401.48
210102	Нэмэгдэл	301,017,736.56	243,396,501.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	69,866,507.05	141,813,855.60
210104	Урамшуулал	1,911,200.00	11,563,167.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,694,589.19	188,032,753.85
210201	Тэтгэврийн даатгал	144,694,589.19	117,769,373.85
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	18,282,412.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	16,305,397.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	3,835,121.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	31,840,450.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,911,158.00	139,820,800.00
210301	Гэрэл, цахилгаан	32,175,000.00	34,073,300.00
210302	Түлш, халаалт	33,742,000.00	32,523,000.00
210303	Цэвэр, бохир ус	13,145,480.00	13,145,500.00
210304	Байрны түрээс	26,848,678.00	60,079,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	199,950,698.12	119,226,094.56
210401	Бичиг хэрэг	54,527,380.00	43,587,560.00
210402	Тээвэр, шатахуун	84,492,325.00	28,580,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,747,468.12	26,091,925.56

**Эрүүл мэндийн яамны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	835,000.00	1,740,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,509,673.00	8,846,108.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	10,380,000.00
210408	Бараа материал акталсны зардал	17,838,852.00	00.00
2105	Нормативт зардал	9,627,540,715.53	12,153,359,241.62
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,536,144,174.53	12,152,383,241.62
210502	Хоол, хүнс	87,930,541.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,466,000.00	976,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,406,657.00	17,299,754.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,812,270.00	5,175,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	209,800.00	500,000.00
210604	Урсгал засвар	9,384,587.00	11,624,754.00
2107	Томилолт, зочны зардал	213,828,126.60	87,059,829.00
210701	Гадаад албан томилолт	34,101,358.60	00.00
210702	Дотоод албан томилолт	179,726,768.00	87,059,829.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,133,319,681.59	1,591,436,944.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,107,267,247.59	1,534,532,598.67
210803	Даатгалын үйлчилгээ	1,289,700.00	1,289,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	574,500.00	574,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	296,104.00	30,000.00
210807	Газрын төлбөр	260,400.00	260,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	63,350.00	2,947,305.59
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	23,568,380.00	51,802,440.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,642,050,581.23	3,129,245,556.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	922,048,233.39	2,644,773,778.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	233,028,470.00	20,583,303.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	486,973,877.84	463,888,474.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,119,836,026.75	898,733,480.07
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	34,352,400.00	41,593,452.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	34,352,400.00	41,593,452.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	492,363,025.40	557,937,568.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,394,005.40	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	440,121,020.00	442,969,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	85,022,854.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,848,000.00	29,945,714.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	593,120,601.35	299,202,460.07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	593,120,601.35	299,202,460.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-170,071,334.27</u>	<u>-15,639,055.70</u>
22	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	<u>00.00</u>	<u>200,000.00</u>
220	Үйл ажиллагааны бус орлого	00.00	200,000.00
2201	Төсөвт байгууллагын орлого	00.00	200,000.00
22010	Дансны орлого	00.00	200,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,145,659,757.33
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	926,890,666.87
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	1,218,769,090.46
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-2,145,659,757.33
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-170,071,334.27</u>	<u>-2,161,098,812.03</u>

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	15,236,222,824.40	19,831,208,872.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	720,386,980.52	633,540,384.00
120	Нийтлэг татварын бус орлого	720,386,980.52	633,540,384.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	720,386,980.52	633,540,384.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	639,575,534.00	622,784,334.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	10,756,050.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	80,811,446.52	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,515,835,843.88	19,197,668,488.44
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	12,555,182,700.00	15,452,574,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,555,182,700.00	15,452,574,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,960,653,143.88	3,745,094,488.44
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,507,065,234.60
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	1,480,392,821.44	82,479,148.84
131103	ЗГНХ, ЗДНХерөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	458,857,000.00	2,126,215,281.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,382,500.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,020,822.44	29,334,824.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	15,261,114,606.96	19,422,190,267.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,261,114,606.96	19,422,190,267.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,050,484,276.76	18,522,135,792.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,460,274,387.53	1,562,663,371.37
210101	Үндсэн цалин	1,113,273,321.32	1,123,717,103.48
210102	Нэмэгдэл	269,490,359.16	261,952,607.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	69,866,507.05	160,255,537.06
210104	Урамшуулал	7,644,200.00	16,738,123.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,942,500.00	193,762,700.00
210201	Тэтгэврийн даатгал	154,942,500.00	115,368,131.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	22,972,671.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	18,378,177.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	4,594,494.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	32,449,227.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,168,554.00	139,820,800.00
210301	Гэрэл, цахилгаан	32,175,000.00	34,073,300.00
210302	Түлш, халаалт	32,523,000.00	32,523,000.00
210303	Цэвэр, бохир ус	13,145,480.00	13,145,500.00
210304	Байрны түрээс	31,325,074.00	60,079,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	180,720,476.12	99,254,093.56
210401	Бичиг хэрэг	54,255,160.00	44,463,560.00
210402	Тээвэр, шатахуун	83,326,275.00	17,997,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,747,468.12	26,091,925.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	835,000.00	1,510,500.00

Эрүүл мэндийн яамны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,556,573.00	9,191,108.00
2105	Нормативт зардал	9,646,710,420.53	12,150,539,241.62
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,544,891,979.53	12,148,938,241.62
210502	Хоол, хүнс	98,352,441.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,466,000.00	1,601,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,320,557.00	30,695,725.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,451,170.00	5,175,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	209,800.00	500,000.00
210604	Урсгал засвар	9,659,587.00	25,020,725.00
2107	Томилолт, зочны зардал	216,802,431.60	88,786,829.00
210701	Гадаад албан томилолт	34,620,963.60	00.00
210702	Дотоод албан томилолт	182,181,468.00	88,786,829.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,115,824,845.59	1,587,294,850.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,088,956,891.59	1,532,106,498.67
210803	Даатгалын үйлчилгээ	1,289,700.00	1,289,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	574,500.00	574,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	296,104.00	30,000.00
210807	Газрын төлбөр	260,400.00	260,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	63,350.00	221,312.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	24,383,900.00	52,812,440.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,151,720,104.39	2,669,318,181.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	910,545,996.39	2,648,734,878.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	241,174,108.00	20,583,303.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,210,630,330.20	900,054,474.66
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	42,667,554.61	42,914,445.59
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	1,320,993.59
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	42,667,554.61	41,593,452.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	492,363,025.40	557,937,569.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,394,005.40	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	440,121,020.00	442,969,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	85,022,854.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,848,000.00	29,945,714.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	675,599,750.19	299,202,460.07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	675,599,750.19	299,202,460.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-24,891,782.56</u>	<u>409,018,605.41</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	41,609,125.00	391,463,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	41,609,125.00	391,463,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	41,609,125.00	391,463,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	41,609,125.00	391,463,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-41,609,125.00</u>	<u>-391,463,100.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-66,500,907.56	17,555,505.41
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	67,866,202.22	1,365,294.66
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,365,294.66	18,920,801.07

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,646,011,001.40	404,338,070.38	1,148,185,969.09	4,198,535,040.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,646,011,001.40	404,338,070.38	1,148,185,969.09	4,198,535,040.87
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн				0.00
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,011,001.40	404,338,070.38	1,148,185,969.09	4,198,535,040.87
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,646,011,001.40	404,338,070.38	1,148,185,969.09	4,198,535,040.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00		0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,646,011,001.40	404,338,070.38	1,148,185,969.09	4,198,535,040.87
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	873,958,968.04	0.00	873,958,968.04
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	96,589,540.00	0.00	0.00	96,589,540.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-2,161,098,812.03	-2,161,098,812.03
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,742,600,541.40	1,278,297,038.42	-1,012,912,842.94	3,007,984,736.88

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэмнэлт, хэтрэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,990,565,430.00	15,964,571,909.53	25,993,520.47	99.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,990,565,430.00	15,964,571,909.53	25,993,520.47	99.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,390,948,330.00	15,363,719,895.94	27,228,434.06	99.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,563,022,400.00	1,562,663,371.37	359,028.63	99.98
210101	Үндсэн цалин	1,124,883,300.00	1,123,717,103.48	1,166,196.52	99.90
210102	Нэмэгдэл	264,124,700.00	261,952,607.83	2,172,092.17	99.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	157,542,000.00	160,255,537.06	-2,713,537.06	101.72
210104	Урамшуулал	16,472,400.00	16,738,123.00	-265,723.00	101.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	193,762,700.00	193,762,700.00	00.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	130,841,800.00	115,368,131.00	15,473,669.00	88.17
210202	Тэтгэмжийн даатгал	15,730,200.00	22,972,671.00	-7,242,471.00	146.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,584,200.00	18,378,177.00	-5,793,977.00	146.04
210204	Ажилгүйдлийн даатгал	3,146,000.00	4,594,494.00	-1,448,494.00	146.04
210205	Эрүүл мэндийн даатгал	31,460,500.00	32,449,227.00	-988,727.00	103.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	139,820,800.00	139,820,800.00	00.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	34,073,300.00	34,073,300.00	00.00	100.00
210302	Түлш, халаалт	32,523,000.00	32,523,000.00	00.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	13,145,500.00	13,145,500.00	00.00	100.00
210304	Байрны түрээс	60,079,000.00	60,079,000.00	00.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,784,930.00	103,784,893.56	36.44	100.00
210401	Бичиг хэрэг	43,022,700.00	44,463,560.00	-1,440,860.00	103.35
210402	Тээвэр, шатахуун	18,400,000.00	17,997,000.00	403,000.00	97.81
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,886,700.00	26,091,925.56	4,794,774.44	84.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	980,130.00	1,510,500.00	-530,370.00	154.11
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,495,400.00	13,721,908.00	-3,226,508.00	130.74
2105	Нормативт зардал	12,152,079,800.00	12,150,539,241.62	1,540,558.38	99.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,149,589,800.00	12,148,938,241.62	651,558.38	99.99
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,490,000.00	1,601,000.00	889,000.00	64.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	416,784,300.00	397,615,921.00	19,168,379.00	95.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	343,345,900.00	326,286,796.00	17,059,104.00	95.03
210602	Тавилга	48,000,000.00	45,808,400.00	2,191,600.00	95.43
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	530,800.00	500,000.00	30,800.00	94.20
210604	Урсгал засвар	24,907,600.00	25,020,725.00	-113,125.00	100.45
2107	Томилолт, зочны зардал	75,017,800.00	73,269,829.00	1,747,971.00	97.67
210702	Дотоод албан томилолт	75,017,800.00	73,269,829.00	1,747,971.00	97.67
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	633,389,200.00	629,965,208.00	3,423,992.00	99.46

Эрүүл мэндийн яамны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	577,850,600.00	574,800,356.00	3,050,244.00	99.47
210803	Даатгалын үйлчилгээ	1,289,700.00	1,289,700.00	00.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	574,500.00	574,500.00	00.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	297,000.00	30,000.00	267,000.00	10.10
210807	Газрын төлбөр	260,400.00	260,400.00	00.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	297,000.00	197,812.00	99,188.00	66.60
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	52,820,000.00	52,812,440.00	7,560.00	99.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,286,400.00	112,297,931.39	988,468.61	99.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,658,400.00	91,714,628.39	943,771.61	98.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,628,000.00	20,583,303.00	44,697.00	99.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	599,617,100.00	600,852,013.59	-1,234,913.59	100.21
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	41,594,400.00	42,914,445.59	-1,320,045.59	103.17
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	1,320,993.59	-1,320,993.59	
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	41,594,400.00	41,593,452.00	948.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	558,022,700.00	557,937,568.00	85,132.00	99.98
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	442,969,000.00	442,969,000.00	00.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,053,700.00	85,022,854.00	30,846.00	99.96
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000,000.00	29,945,714.00	54,286.00	99.82
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	1,365,294.66		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	18,920,801.07		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.22	Аудитын нэр:	Эрүүл мэндийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/63/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Эрүүл мэндийн яам		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 229 дүгээр "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" тогтоолоор Монгол Солонгосын дорно дахины анагаах ухааны төв"-ийн эзэмшиж байгаа 105,613.4 мянган төгрөгийн өртөгтэй эмнэлгийн барилгыг данс бүртгэлд тусгасан боловч хөрөнгийн дахин үнэлгээг хийлгээгүй байна.	105,613.4	Албан шаардлага хүргүүлэх	Нягтлан бодогч	О.Уранчимэг
2	Эрүүл мэндийн яамны 31 албан хаагчдад ээлжийн амралтын олговрыг бодож олгохдоо өмнөх оны амралтын мөнгийг дундаж цалинд оруулан тооцож нийт 6,855.4 мянган төгрөг, мөн амралтын дундаж цалинд унаа, хоолны хөнгөлөлтийг оруулан 50 албан хаагчид нийт 4,580.5 мянган төгрөг нийт 11,435.4 мянган төгрөгийг илүү олгосон байна.	11,435.4	Албан шаардлага хүргүүлэх	Нягтлан бодогч	О.Уранчимэг
3	"Мөнхийн тун" ХХК-д вакцин бараа нийлүүлэх 3 гэрээг 3,126,697.9 мянган төгрөгөөр байгуулсан боловч санхүүжилт олгохдоо 4,074.8 мянган төгрөгөөр илүү олгосон, гэрээний үүргийн биелэлтийн 5 хувь буюу 25,020.9 мянган төгрөгийг дутуу байршуулсан байна. Мөн "Мөнхийн тун" ХХК "Галзуугийн эсрэг вакцин" нийлүүлэх тендер шалгаруулалтаар "Хамгийн сайн" үнэлэгдэж, 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 2/57 дугаар албан бичгээр гэрээ байгуулах эрх хүргүүлж, 5 хоногийн дараа байгуулах атал бараа ажил үйлчилгээ нийлүүлэх гэрээг 01 дүгээр сарын 06-ны өдрөөр 01 дүгээр гэрээ байгуулж холбогдох хуулийн заалтыг зөрчсөн байна.	29,095.7	Албан шаардлага хүргүүлэх	Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч	Э.Содном жамц
4	2018 оны 12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийг 5,665.8 мянган төгрөгөөр илүү төлж төсвийн хэмнэлтийн мөнгийг зарцуулсан, авлага үүсгэсэн.	5,665.8	Акт тогтоох	Нягтлан бодогч	О.Уранчимэг
5	Багаж хэрэгслийн зардлаас 8,411.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 8,894.5 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 6,380.3 мянга, бусад зардлаас 1,460.0 мянга, нэмэлт санхүүжилтийн данснаас 7,757.6 мянган	22,027.5	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	О.Уранчимэг

	төгрөг нийт 22,027.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй, мөн зориулалтын бус зардлаас хөрөнгө бэлтгэсэн байна.				
6	"Эрүүл мэндийн салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах" 2018 оны 02 дугаартай 9,500.0 мянган төгрөгийн үнэтэй гэрээг Мишээл-Од аудит ХХК-тай байгуулсан бөгөөд ажлын хөлсийг гэрээний гүйцэтгэлгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.	9,500.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	О.Уранчимэг
	Дүн	183,337.8			

